

**БАГАНУУР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРААС
АВЛИГЫН ЭСРЭГ 2014 ОНД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭХ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

ЗОРИЛГО: Авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлж, авлигаас урьдчилан сэргийлэх, мэдээллийн ил тод нээлттэй байдлыг хангах

д/д	Хэрэгжүүлэх ажил	Хугацаа	БИЕЛЭЛТ
НЭГ. ЁС ЗҮЙТЭЙ МАНЛАЙЛЛЫГ ХАНГАХ			
1.1	Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан боловсруулж батлуулах, төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хагас жил тутам нэгтгэх	Оны эхэнд	Төлөвлөгөөнд тусгагдсан зорилго зорилтыг ханган ажилласан. 2014 оны оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулж АТГ болон НЗДТГ-т хүргүүлсэн. /Төлөвлөгөөг АТГ-т хүргүүлсэн/
1.2	ЗДТГ-ын Албан тушаалтны гүйцэтгэх чиг үүргийг ажлын байрны тодорхойлолт болон ажил үүргийн хуваарьт тодорхой тусгаж, цахим хуудсанд тавих хувь хүний нууцтай холбогдох мэдээллийн хадгалалт, хамгаалалтын байдлыг хангах.	Жилдээ	Төрийн албаны зөвлөлийн 2004 оны 34 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан загварын дагуу зарим Төрийн албан хаагчдын Ажлын байрны тодорхойлолтыг 2014 онд шинээр боловсруулж, ажлын байрны давхардал, хийдлийг арилган үйл ажиллагаанд хяналт тавин ажиллаж байна. /Ажлын байрны тодорхойлолтуудыг дүүргийн цахим сайтад байршуулсан./
1.3	Төрийн байрнаас төрийн үйлчилгээ эрхэлдэгээс бусад аж ахуйн нэгж, байгууллага, компанийг гаргах		Төр захиргааны байранд одоогоор Дэлхийн зөн ОУБ ТББ, ТББ-уудын Үйдвэрчний Эвлэлийн хороо, Ажил олгогч эздийн холбоо, Мал сүргийг гэмт халдлагаас хамгаалах нийгэмлэг зэрэг байгууллагууд түрээсгүй үйл ажиллагаагаа явуулж байна.
1.4	Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах /мэдээллийн самбар, цахим хуудас, теле сурталчилгаа, яриа таниулга, сонсгол, нээлттэй өдөрлөг, хэлэлцүүлэг, хэвлэмэл материал, шторк г.м/		Төрийн албан хаагчдад болон иргэдэд Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах зорилгоор ЗДТГ-ын 2-р давхрын коридорт “АВЛИГАГҮЙ БАГАНУУР”, Худалдан авах ажиллагааны албаны дэргэд “ТЕНДЕРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ АВЛИГАГҮЙ ЗОХИОН БАЙГУУЛАХ” самбаруудыг тус тус байршуулж, мэдээ мэдээллийг нээлттэй ил тод хүргэн ажиллаж байна. Дүүргийн цахим

		Жил бүрийн эхэнд	<p>хуудсанд холбогдох мэдээ мэдээллийг цаг хугацаанд нь тавьж хэвшээд байна.</p> <p>Ä¿¿ðàèéí ò°ð çàðèðàààíû албан хаагчдад Äàèèààðàè öýìöýð äàçàððàèè ðàìððàì “Õóàèéí àøèã ñîèèððèí ç°ð÷-è°ñ óðüä÷-èèàí ñýðàèèéýð áíèíí Õ°ð°íà° ìðèíäüí ÿä¿¿èýã” öýðöýí ÿä¿¿èýð òàèààð ñóðààèè çìèèí äàèèòóèæ, ЗДТГ болон дэргэдэх хэлтсүүдийн нийт 100 гаруй төрийн албан хаагч оролцлоо.</p> <p>“Шударга залуу хүний баримтлах 7 зарчим” сэдэвт сургалтыг АТГ-тай хамтран дүүргийн ЕБС-ийн ахлах ангийн 180 сурагчдад зохион байгуулсан.</p> <p>Авлигын эсрэг сурталчилгааны материалуудыг дүүргийн нийт 30 байгууллагуудад 2014 оны 3 дугаар сард тарааж албан өрөө, коридорт иргэдэд ил харагдахуйц газар нааж байршуулсан.</p> <p>/Зургийг хавсаргав./</p>
1.5	Боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг цахим хуудсанд байршуулах, иргэд, олон нийт, сонирхогч бүлгийн санал, шүүмжлэлийг хүлээн авах, харилцан санал солилцох боломжийг бүрдүүлэх саналыг тусгах	Улирал тутам	<p>Боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг /Засаг даргын захирамж, ТГ-ын даргын тушаал/ цахим хуудсанд байршуулж, нутгийн захиргааны байгууллагуудын удирдах ажилтны шуурхай зөвлөгөөн дээр танилцуулж иргэд, олон нийтээс санал, шүүмжлэлийг хүлээн авах, харилцан санал солилцох боломжийг бүрдүүлэх зорилгоор дүүргийн 5-н хороо буюу хүн ам төвлөрсөн нийт 29 газарт нийтийн зарын самбар байршуулж мэдээллийг 7 хоног бүр сольж байна.</p> <p>Хууль зүйн үндэсний хүрээлэнтэй хамтран Хүний эрх, Хөдөлмөрийн эрх зүйн сургалтыг 1 дүгээр сард зохион байгуулсан. Олон нийт цагдаагийн хамтын ажиллагаа, Захиргааны тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Согтууруулах ундааны хяналтын тухай хуулийн төслийн хэлэцүүлэгийг Иргэний танхимд зохион байгуулж, давхардсан тоогоор 150 иргэн хамрагдав. Төрийн үйлчилгээг иргэдэд хөнгөн шуурхай хүргэх зорилгоор дүүргийн Засаг даргын Тамгын</p>

			<p>газраас төр захиргааны байгууллагын болон төрийн үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх, иргэдийн сэтгэл ханамжийн баталгааг авах санал асуулгыг жилд 2 удаа авч үр дүнг тооцон ажиллалаа.</p>
1.6	Төрийн болон байгууллагын нууцад хамаарах мэдээллийг ашиглах хамгаалах журмыг шинэчлэн батлах		<p>Батлагдсан журмын дагуу мөрдөн ажиллаж байна.</p> <p>ЗДТГ-ын даргын 2014 оны А/01 дугаар тушаалаар “Нууцын баталгаа гаргуулах тухай” тушаалаар /нийт 27 албан хаагч/ Нууц бичиг баримттай харьцдаг албан хаагчдын нэрсийг батлуулж, хууль журмын дагуу нууцын нэмэгдлийг олгон ажиллаж байна.</p> <p>/Тушаалыг хавсаргав/</p>
1.7	Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн зөвлөмж, шийдвэр, албан бичгийн бүртгэлийг хөтлөх, хэрэгжилтийг хангах зохион байгуулалтын арга хэмжээг авах.		<p>АТГ-аас ирүүлсэн “Төрийн байгууллага дах Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны гарын авлага”, “ХОМ гаргагч нарт зориулсан гарын авлага-3”, “Авлигын талаарх олон нийтийн ойлголт, мэдлэг тогтоох судалгаа”, “Авлигын эсрэг хууль тогтоомжийг таниулах нь” “Бизнес эрхлэлтийн орчин дахь авлигын нөхцөл байдал” гарын авлагуудыг ЗДТГ-ын хэлтсүүдэд болон Хороодод хүлээлгэн өгч, иргэдэд мэдээлэл түгээн ажиллаж байна.</p>
1.8	Авлига гарах нөхцөл, боломжийг бүрдүүлж болзошгүй байгууллагын дотоод үйл ажиллагаанд болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон дүрэм, журам, заавар, шийдвэрийг авлигатай тэмцэх газарт хүргүүлж хянуулах		<p>Ашиг сонирхлын зөрчил үүсч ажилд томилогдсон 1 ажилтны /Олон нийт, Хэвлэл мэдээлэл хариуцсан мэргэжилтэн М.Гэрэлтуяа/ талаар АТГ-т санал хүргүүлж, шалгуулж Ажлаас чөлөөлөх шийдвэрийн дагуу хэрэгжилтийн ханган ажилласан.</p>
1.9	Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний нээлттэй байдлыг хангах		<p>Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр нээлттэй байдлыг хангах зорилгоор хүний нөөц, төрийн албаны стандарттай холбогдолтой баримт бичгүүдийг цахим хуудсанд байршуулж ажиллалаа.</p>
1.10	Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх, урамшуулах үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга		<p>ЗДТГ-ын Төрийн захиргааны болон Төрийн үйлчилгээний албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг бодитой үнэлэх, ажиллах идэвхийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 2,3-р</p>

	хэмжээний нээлттэй байдлыг хангах		улиралд 6 сараас дээш ажилласан 80 хүнд 10-40 хувийн урамшуулал олгосон. /Тушаал, хавсралтыг хавсаргав/
1.11	Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт, мэдээллийг хэрхэн шийдвэрлэсэн талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр тогтмол хугацаанд мэдээлэх		2014 оны 11 сар хүртэл нийт 864 өргөдөл, гомдол ирснийг http://smartcity.mn цахим хуудсанд 100% бүртгэсэн. Иргэдийн өргөдөл хүсэлтийг цаг тухайд нь шийдвэрлэж шийдвэрлэлтийн хариуг эзэнд нь мэдэгдсэн. Өргөдөл гомдлын мэдээг улирал тутам гаргаж НЗДТГ-ын Иргэд хүлээн авах төвд хүргүүлсэн. Дүүргийн ИТХТ-ийн хуралд хагас жилээр мэдээ тайланг танилцуулж ажиллалаа. Тусламж хүссэн иргэдийн гэрээр орж зураг авч Удирдлагын зөвлөлийн хурлаар оруулан шийдвэрлэж байна. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн мэдээг цахим хуудсанд байршуулсан. /Өргөдлийн тайланг хавсаргав/
1.12	Сайд, нийслэлийн Засаг дарга нараас /дээд байгууллагаас/ шалгуулахаар шилжүүлсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн талаар тайлагнах		Засгийн газрын 11-11 төвөөс http://smartcity.mn цахим хуудсаар 3 хүсэлт, 1 талархал ирснийг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн. Нийслэлийн иргэд хүлээн авах төвд дүүргийн 4 дүгээр хорооны иргэн Ц.Памаа хүү Одбаярын эмчилгээний төлбөрт мөнгөн тусламж хүссэн өргөдөл ирүүлсэнийг шийвэрлэж ЗДНС-аас 300.000 төгрөгийн буцалтгүй тусламж үзүүлсэн. Нийслэлийн Засаг даргад хандан дүүргийн 1 дүгээр хорооны иргэн Д.Пүрэв газар хүссэн өргөдөл ирүүлсэнийг шийдвэрлэж 3 дугаар хорооны Нугын тал хэсэгт 0,07га газар өмчлөлөөр олгосон.
1.13	Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх /хүнд суртал, чирэгдлийг багасгах, сөрөг үзэгдлийг хаах, ашиг сонирхлын зөрчлийн мэдүүлгийг хянах, албан хаагчийн ажлын байрыг сэлгүүлэх зэрэг үр дүнтэй арга хэмжээг зохион байгуулах/		Дүүргийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2014 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 70 дугаар тогтоолоор “Авлигатай тэмцэх ажлыг зохицуулах, хяналт тавих дэд зөвлөлийн бүрэлдэхүүн”-ийг баталж, зөвлөлийн даргаар ДИТХТ-ийн нарийн бичгийн дарга ажиллахаар боллоо. Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих ёс суртахуун төлөвшүүлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр ажиллах Засаг даргын дэргэд орон тооны

			<p>бус 3 зөвлөх ажиллуулахаар удирдлагын зөвлөлийн хурлаас шийдвэрлэлээ.</p> <p>2013 онд дүүргийн Засаг даргын захирамжаар төсвийн байгууллагуудын нягтлан бодогч нарыг сэлгүүлэн ажиллуулах арга хэмжээг авч ажилласнаар төсвийн сахилга бат сайжирсан.</p> <p>/Тогтоолыг хавсаргав/</p>
ХОЁР. ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ШУДАРГА БАЙДЛЫГ ХАНГАХ			
2.1	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын албан хаагчдын ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хамт олонд мэдээлэх, мэдээ, тайланг Төрийн албаны зөвлөл, Авлигатай тэмцэх газарт хүргүүлэх	жилдээ	<p>Засгийн газрын 2010 оны 288 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг нийт албан хаагчдад танилцуулж, хэлтсүүдэд файл хэлбэрээр болон цаасаар хуулбарлан хүргүүлж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах байна.</p> <p>Энэ онд ёс зүйн зөрчил гаргасан ажилтан албан хаагч байхгүй.</p>
2.2	Ёс зүй, Авлигаас урьдчилан сэргийлэх, хувийн ашиг сонирхол болон хөрөнгө орлогын мэдүүлгийг үнэн зөв мэдүүлэх, Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг, мэдэгдэл, хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд гаргах сургалт зохион байгуулах	Улирал тутам	<p>Нийтийн албанд нэр дэвшиж буй этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг, ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд гаргуулан тайланг Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн.</p> <p>Нийтийн албанд шинээр томилогдсон нийт 25 иргэний Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулж ажилд томилсон.</p> <p>Дүүргийн ИТХ-ийн 25 Тэргүүлэгчдэд Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг, мэдэгдэл, хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд хэрхэн гаргах талаар сургалт зохион байгуулсан.</p>
2.3	Дүүргийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдах албан хаагчдын ёс зүйн дүрмийг батлуулж мөрдүүлэх	жилдээ	<p>Нийслэлийн Засаг даргын 2013 оны 04 дүгээр сарын 22 -ны өдрийн А/419 дүгээр захирамжийн 2 дугаар хавсралтаар батлагдсан “НИЙСЛЭЛИЙН НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН УДИРДАХ АЛБАН ТУШААЛТНЫ ЁС ЗҮЙН ДҮРЭМ”-ийг нутгийн захиргааны байгууллагуудын удирдах ажилтны шуурхай зөвлөгөөн дээр ААНБ-уудын удирдлагуудад танилцуулсан.</p> <p>2014 онд Ёс зүйн зөрчил гаргасан удирдах албан хаагч байхгүй.</p>

2.4	Хүний нөөцийн сонгон шалгаруулалт, ажлын байрны сул орон тооны талаар мэдээллийн хэрэгслээр болон цахим хуудсаар олон нийтэд зарлах,	Тухай бүр	Дүүргийн ЗДТГ-аас нийт 15 сул ажлын байр зарлагдахаар хүсэлтээ нийслэлийн Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд хүргүүлээд байна. /2014 оны 5 сард зарлуулахаар хүсэлт гаргасан боловч Засаг даргын асуудлаар маргаантай байсан тул нийслэлээс хойшлуулсан болно./ Сул ажлын байрыг дүүргийн цахим хуудсанд байршуулсан. 6 ажилтан нийслэлд зарлагдсан Төрийн Албаны шалгалтад тэнцэж, 10 дугаар 24-нд ТЖАХ-ийн тангараг өргөөд байна.
2.5	Авлигад өртөх эрсдэлтэй ажил, албан тушаал, үйлчилгээний жагсаалтыг гаргаж цахим хуудсанд байршуулах	Жилдээ	Авлигад өртөх эрсдэлтэй ажил, албан тушаал, үйлчилгээний жагсаалтыг нийт 32 ажилтнуудаас асуулгаар авч цахим хуудсанд байршуулсан. Худалдан авах ажиллагааны албан хаагчдын ажил үүргийн хуваарь, албаны танилцуулгыг мэдээллийн самбар болон дүүргийн вэб сайтын худалдан авах ажиллагааны ил тод байдал буланд байршуулсан.
2.6	Хууль болон Засгийн газраас зөвшөөрсөн давхар эрхэлж болох ажлын жагсаалтыг албан хаагчдад танилцуулах. Холбогдох журмын дагуу давхар ажил эрхлэх зөвшөөрлийг олгох, давхар ажил эрхлэлттэй холбогдсон хязгаарлалтыг хэрэгжүүлэх.	жилдээ	Албан хаагчдаас давхар ажил эрхэлж, ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэл авдаг албан хаагч 5 байна. Санхүү төрийн сангийн хэлтсийн мэргэжилтнүүд хувиараа компаниудын тайлан гаргадаг байсныг таслан зогсоосон. Давхар ажил эрхэлдэг ажилтан байхгүй.
2.7	Байгууллагын тухайн жилийн төсөв, төсвийн орлого бүрдүүлэлт /татварын орлого, татварын бус орлогын талаарх мэдээлэл/ мэдээллийг цахим хуудсанд буюу төсвийн самбарт байршуулах	Сар бүр	Байгууллагын тухайн жилийн төсөв, төсвийн орлого бүрдүүлэлт талаарх мэдээллийг цахим хуудсанд болон, ЗДТГ-т байрлах Төсвийн самбарт байршуулсан. Төсвийн орлого бүрдүүлэлтийг нээлттэй байлгах зорилгоор Татварын орлого, татварын бус орлогын талаар цахим хуудсанд байршуулсан.
2.8	Үйлчлүүлэгчээс авч буй төлбөр, хураамжийн талаарх мэдээлэл, зөвшөөрөл олгоход шаардлагатай баримт бичгийн жагсаалт, олгосон зөвшөөрөл, зөвшөөрөл эзэмшигчийн нэр хаяг, үйл ажиллагааны чиглэл,	Жилдээ	Тамхины хяналтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дэх хэсэг, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3.4 дэх заалтын дагуу Тамхи худалдах тусгай зөвшөөрлийг 16 компанид олгож үйл ажиллагаа явуулж байна.

	зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудсанд байршуулах		Тусгай зөвшөөрлийн хураамж: 250,000, гэрчилгээний хэвлэлийн зардал 3000, нийт 253,000 төгрөг тушаана. Рекламны самбарыг нийт 14 байгууллага, ААН-үүд эзэмшиж байна. Түрээсийн төлбөр 1 м2 нь 80000 төгрөгийн төлбөртэй. Энэ талаарх мэдээллийг иргэдэд хүргэх зорилгоор цахимд байршуулсан. /Судалгааг хавсаргав/
2.9	Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт /4 дүгээр сарын 1-ний дотор/-ийг бүрэн эхээр нь цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулах	4 дүгээр сарын 1-ний дотор	Санхүүгийн тайланд хийсэн хагас жилийн Аудитын дүгнэлтийг цахим хуудсанд байршуулсан.
2.10	Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийн жагсаалтыг тухайн этгээдийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэрийн хамт цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байршуулах	Жилдээ	Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийн жагсаалтыг цахим хуудсанд тавиагүй. /Дүүргийн НДХ-ээс нууцын зэрэглэлтэй тул боломжгүй гэсэн/
2.11	Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулах	Тухай бүр	Дүүргийн ЗДТГ-ын байранд ажиллаж буй байгууллагуудын ажилтнуудын албан тушаал, ажлын байрны утасны дугаар зэрэг мэдээллийг иргэдэд үзэгдэхүйц 1 давхрын вестибюлд байрлуулж, цахим хуудсанд мөн байршуулсан.
2.12	Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, түүний хэрэгжилтийн талаарх мэдээллийг цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулах	Улирал бүр	Тайваны Хүүхэд гэр бүлийг дэмжих сантай хамтран эмзэг бүлгийн хагас бүтэн өнчин хүүхдүүдийг хүүхэд хамгаалал хөтөлбөрт хамруулах ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулж 120 гаруй өрхөд дулаан хөнжил, гурил будаа, 40 гаруй хүүхдэд нярайн нэмэлт тэжээл, хүнсний бүтээгдэхүүнээр хангаж 12 гаруй сая төгрөгийг зарцуулсан байна. Дэхийн зөн Монгол Олон улсын байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулсны дагуу 2014 онд суурь

			судалгааны үе дуусч, хөтөлбөр эхлэх бэлтгэл ажлууд хангагдаж эхлээд байна. 2014 онд Хүүхэд ивээн тэтгэх хөтөлбөрт эмзэг бүлгийн 1000 хүүхдийг хамруулах болсон. Үндэсний хөтөлбөр Нийгмийн салбарт-20, эрх зүй-1, байгал орчин-1, ХХАА-1, бэб бүтэц-2, соёл урлагийн салбарт-5, боловсролын салбарт-7 хөтөлбөр хэрэгжиж байна.
2.13	АТГ-ын даргын 2012 оны 74-р тушаалаар батлагдсан “Албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэх журам”-ын биелэлтийг хангуулах	жилдээ	АТГ-ын даргын 2012 оны 74-р тушаалаар батлагдсан “Албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэх журам”-ыг ажилтнуудад танилцуулсан.
2.14	Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдын судалгаа гаргах		2014 онд ЗДТГ-т нийт 48 хүн шинээр томилогдсоноос 23 албан хаагчийн ХАСХОМ-ийг АТГ-аар хянуулан ажилд томилсон байна. /Шинээр томилогдсон албан хаагчдын судалгааг тайлбарын хамт хавсаргав/
ГУРАВ. ТОГТОЛЦООНЫ ШУДАРГА БАЙДЛЫГ ХАНГАХ			
3.1	Дүүргийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдлагаас гаргаж буй шийдвэрийн төсөлд төрийн болон төрийн бус байгууллага, олон нийтийн зүгээс саналаа илэрхийлэх санал асуулгыг явуулах	Хагас бүтэн жилд	ХААА-наас зарласан тендерийн хороонд иргэд, ТББ-уудын төлөөллийг оролцуулж, Засаг даргын захирамжаар Ажлын хэсэг байгуулж шийдвэрлэдэг. /Үнэлгээний хороо байгуулсан тухай Засаг даргын захирамжийн хуулбарыг хавсаргав./
3.2	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлах	1 дүгээр улиралд	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг цахим хуудсаар нийтэд зарлаж байна.
3.3	Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилгыг өдөр тутмын сонин болон цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулах	Тухай бүр	Тендертэй холбоотой үйл ажиллагааны талаарх дэлгэрэнгүй мэдээллийг өдөр тутмын сонин болох “Өдрийн сонин”-д болон цахим хуудсанд тухай бүр байршуулж хэвшсэн. /материалыг хавсаргав/

3.4	Тендерт оролцохыг сонирхогчдод тавих шалгуур үзүүлэлт болон гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан үндэслэлийн талаарх нээлттэй байдлыг хангах	Тухай бүр	Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилгыг Сангийн яамны e-procurement.mn, дүүргийн сайтуудад болон мэдээллийн самбарт байршуулан ажиллаж байна. Тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт болон гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээллийг цахимд байршуулсан
3.5	Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээллийн дүгнэлтийн нээлттэй байдлыг хангах	Тухай бүр	Төр захиргааны байгууллагуудын байрны дутагдалтай байдлаас үүсэн нэг цонхны үйлчилгээ явуулахгүй байгаа. 2015 оноос хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.
3.6	Төрийн байгууллагын үйлчилгээнд нэг цонхны зарчмыг мөрдүүлэх журмыг баталж хэрэгжүүлэх		
ДӨРӨВ. ХАРИУЦЛАГА, ХЯНАЛТЫН МЕХАНИЗМЫГ САЙЖРУУЛАХ			
3.7	Худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг цахим хуудсанд мэдээлэх		Тендертэй холбоотой үйл ажиллагааны талаарх дэлгэрэнгүй мэдээллийг дүүргийн цахим хуудсанд тухай бүр байршуулж хэвшсэн.
3.8	Тендер шалгаруулах явцад илэрсэн зөрчлийн талаар холбогдох байгууллагад мэдээлэх		Гарсан зөрчлийн талаар 3 байгууллагын тендерийн үйл явцтай холбоотой асуудлаар Сангийн яаманд мэдээлж албан тоот хүргүүлж шийдвэрлэсэн. /материалыг хавсаргав/
3.9	Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүнгийн талаарх нээлттэй байдлыг хангах	Тухай бүр	Нийслэлийн Аудитаас худалдан авах ажиллагаанд хяналт шалгалт хийсэн дүнг цахим хуудсанд байршуулсан.
3.10	Тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулах		ХААА-наас зарласан тендерийн хороонд иргэд, ТББ-уудын төлөөллийг оролцуулж шийдвэрлэдэг. /дүүргийн Засаг даргын захирамжаар/
3.11	Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, бусад хяналт шалгалтын дүнг мэдээлэх		Удирдлагын зөвлөлийн хуралд оруулж танилцуулдаг. Тендер шалгаруулалт, үр дүнгийн талаар цахим хуудсанд мэдээлдэг.
3.12	Худалдан авах ажиллагаа, тендер шалгаруулах явцад зөрчил гаргасан албан хаагчид хариуцлага тооцож, олон нийтэд мэдээлэх	Жилдээ	Зөрчил гараагүй

3.13	<p>Ёс зүйн зөрчлийн талаарх мэдээлэл хүлээн авах нөхцлийг бүрдүүлнэ. /тогтмол утас, цахим хуудас, шуудан, хайрцаг байршуулах/</p>		<p>Төрийн албан хаагчидтай гомдол саналыг 7021-4444 дугаарын утсаар тогтмол авч ажиллаж байна. 2014 онд ТАХ-чидтай холбоотой гомдол ирээгүй.</p>
3.14	<p>Байгууллагын дотоод аудит, хяналт шалгалт, иргэд байгууллагын өргөдөл, гомдлоор илэрсэн зөрчилд хариуцлага тооцож, албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргүүлж хэрэгжилтийг хангах</p>		<p>Иргэдээс ирсэн гомдол байхгүй.</p> <p>3 компаниас /Танил санаа, Баян тогтоц, Фүжи Алтай ХХК/ ирсэн гомдлын дагуу албан бичгийг Сангийн яаманд хүргүүлсэн. /Явуулсан албан тоотыг хавсаргав/</p>

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:
ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН

Б.ЭНХСАЙХАН

ХЯНАСАН:
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

М.БАЯСГАЛАН